



## **ГАРЧИГ**

Мэндчилгээ

“Шарын гол” ХК-ийн танилцуулга

ТУЗ-ийн хурлын тогтоол

ХЭХ-ын үйл ажиллагааны дараалал

Хуралд хэлэлцэх асуудал

ХЭХ-ын тооллогын комиссын тогтоол

2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан

2018 оны аудитын тайлан /хураангуй/

Компанийн засаглал, ТУЗ-ийн ажлын тайлан

ТУЗ-ийн хурлын тогтоол

ХЭХ-ын тогтоолын төсөл

ХЭХ-ын тогтоолын төсөл

ХЭХ-ын тогтоолын төсөл

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга

ХЭХ-ын тогтоолын төсөл

ХЭХ-ын тогтоолын төсөл

ХЭХ-ын тогтоолын төсөл

ТУЗ-ийн хурлын тогтоол

Санал авах хуудас

## МЭНДЧИЛГЭЭ



Монгол улс, бүс орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулан, оюун ухаан хүч хөдөлмөрөө зориулж, үндсэн үүргээ биелүүлсээр ирсэн тус компанийн нийт уурхайчид, хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч түнш байгууллага хамт олон та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн мэндчилье.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа компанийн засаглалын кодекс, зарчмыг мөрдлөг болгон компанийн засаглалын хөгжлийг манлайлагчдын эгнээнд хүрч ажиллахыг зорин ажиллаж байгаа билээ.

Тус компани нь Монгол улсын эдийн засгийн хямралыг даван туулж буй энэ цаг үед компанийн гол зорилго болсон дэлхийн стандартад нийцсэн уул уурхайн компани болох хөгжлийн ирээдүйд чиглэсэн бодлого тодорхойлж боловсронгуй болгон түүнийг хэрэгжүүлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны үйл ажиллагаа чиглэж ирлээ.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйлдвэрийн шинэчлэл, цаашдын үйл ажиллагааны өрнөлттэй уялдуулан зайлшгүй шаардлагатай байгаа машин техник үндсэн хөрөнгө худалдаж авах, түрээсээр авч ажиллуулах тухай үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдсон асуудал, компанийн удирдлага нэгжийн шинэчилсэн бүтцийн тухай, удирдлага зохион байгуулалтын асуудал зэрэг онцгой чухал асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж удирдамжаар хангаж байлаа.

Тус компанийн 2017 оны үйл ажиллагааг үнэлж Монгол улсын Засгийн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран шалгаруулдаг “ТОП-150 аж ахуй нэгж”-ээр шалгаруулсан нь бидний цаашдын ажилд урам зориг, эрч хүч нэмсэн даалгавар гэж үзэж байна.

Бидний цаашдын хөгжил дэвшилд хүрэх зорилго, зорилтоо биелүүлэхэд хувьцаа эзэмшигчид, харилцагч түнш байгууллагууд, уурхайчид нийт хамт олны хүч хөдөлмөр, хичээл зүтгэлээс шалтгаалан, хүндрэл бэрхшээлийг даван туулна гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлье.

Та бүхэнд ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г.ХУЛАН

## МЭНДЧИЛГЭЭ



*Хүндэт хувьцаа эзэмшигчид ээ.*

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчид та бид компанийн 2018 оны үйл ажиллагааны талаар тайлагнан хэлэлцэхээр ээлжит хурлаа хуралдах гэж байна.

2018 оны нүүрс олборлолтын төлөвлөгөө 102.4%, нүүрс борлуулалтын төлөвлөгөө 103,5%-иар биелүүлж, улс орныхоо хойд бүс буюу Дархан, Эрдэнэтийн эрчим хүчний үйлдвэрүүдийн хэрэгцээг хангаж олборлосон нүүрснийхээ 75-80 хувийг эрчим хүчний хэрэглээнд нийлүүлж бусад үйлдвэрүүд, жижиг хэрэглэгчдийг нүүрсээр хангах үүргээ амжилттай биелүүллээ.

2018 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, үндсэн үүргээ биелүүлсэн амжилтаар Дархан-Уул аймгийн “ОНЫ ТЭРГҮҮНИЙ БАЙГУУЛЛАГА”, “ҮНДЭСНИЙ ТОП-150 АЖ АХУЙН НЭГЖ”-д тус тус шалгарсан.

Бид 2019 оноос 2020 оны 6 дугаар сар хүртэлх 1,5 жилд 16,890.0 мян.м<sup>3</sup> хөрс хуулж 1,894.0 мтн нүүрс олборлож 1.819.39 мтн нүүрс борлуулахаар төлөвлөж байгаа нь өндөр үзүүлэлт бөгөөд энэхүү зорилго зорилтоо биелүүлэхэд хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч түнш байгууллагын санал зөвлөмж, идэвхитэй үйл ажиллагаа бөгөөд уурхайчин хамт олны сэтгэл, зүтгэл онцгой нөлөөтэй гэдгийг тэмдэглэж зорьсондоо хүрнэ гэдэгт итгэл төгс байна.

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, уурхайчин хамт олон, бизнесийн түнш хамтран ажиллагсдадаа амжилт бүтээлээр арвин, аз хиймориор дүүрэн байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ “ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БАТБААТАР



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал  
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 2, 3 зүйлийн заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 13 цагаас “Улаанбаатар” зочид буудлын хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.
  - 1) Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, ТУЗ-ийн ажил, засаглалын тайланг мэдээлэх.
  - 2) Компанийн ТУЗ-ийн 2019 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах.
  - 3) Компанийн өрийг хувьцаагаар солих, түүнтэй холбоотойгоор хувьцаа нэмж гаргах.
  - 4) Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах /хувьцаа нэмж гаргасантай холбоотой/
  - 5) Нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэх эсэх.
  - 6) Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
  - 7) Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл
3. Хурал хуралдуулах тухай, хувьцаа эзэмшигчдэд зарлан мэдэгдэх өдрийг 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн хугацааг хурал хуралдах өдрөөр тогтоосугай.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр байхаар тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудасны загварыг хавсралт 1-ээр, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон танилцах бичиг баримтын жагсаалтыг хавсралт 2-оор, хэвлэл мэдээллээр зарлах хурлын зарыг хавсралт 3-аар тус тус баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтыг хуулийн хугацаанд бэлэн болгохыг гүйцэтгэх захирал /Б.Батбаатар/, СТХ /Л.Даваасүрэн/ нарт даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар, ТУЗ-ийн дарга Г.Хуланг томилсугай.
8. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.  
Үүнд: Комиссын дарга: – Г.Хулан - ТУЗ-ийн дарга  
Комиссын гишүүн: - Б.Батбаатар - ТУЗ-ийн гишүүн  
Ж.Эрдэмбилэг - ТУЗ-ийн гишүүн  
М.Мөнхболор-Санхүү эрхэлсэн дэд захирал
9. Хурлын тооллогын комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.  
Үүнд: Комиссын дарга: – Х.Уянга – ХОЭЗХ мэргэжилтэн  
Г.Өэлүн – Хангамжийн ажилтан
10. Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбогдуулан хийгдэх ажил, цаг хугацааны график төлөвлөгөө гаргаж, зохих хууль журмын дагуу хуралдуулахыг комисс /Г.Хулан/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ХУЛАН



SHARYN GOL INC  
THE BOARD OF DIRECTORS  
TTA49511-2050374





### **“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА**

1. Нэр: “Шарын гол” ХК

Үндсэн харьяалал: Монгол улс

2. Хаяг: Дархан-Уул аймаг Шарын гол сум Санжинт баг

Утас: 70372235 Факс: 70372235

3. Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл “Засгийн газрын 2003 оны 162 дугаар тогтоол, төрийн өмчийн хорооны 2003 оны 682 дугаар тогтоолоор 100 хувь, хувийн өмчит компани болсон.

4. Улсын бүргэлийн гэрчилгээний дугаар 1910010009, регистрийн дугаар 2050374

5. Тус компани нь чулуун нүүрс олборлон Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц болон бусад гэрээт байгууллага, компаниудад нийлүүлдэг.

6. Компанийн эрх барих дээд байгууллага нь: Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ бөгөөд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдана.

**“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын үйл ажиллагааны дараалал**

2019.04.26

д/д	Үйл ажиллагаа	Хариуцагч
1.	Хуралд оролцох хувьцааг бүртгэн нэгтгэж хуралд мэдээлэл бэлтгэх	Тооллогын комисс Х.Уянга
2.	Хуралд ирсэн хувьцааны бүртгэлийн дүн бүхий тооллогын комиссын тогтоол танилцуулах	Тооллогын комисс Х.Уянга
3.	ХЭ-ийн хурал нээх	Хурлын дарга Г.Хулан
4.	ХЭ-ийн хуралд хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга Г.Хулан
5.	Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар Ерөнхий инженер Ж.Эрдэнэбат
6.	Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар Санхүү эрхэлсэн дэд захирал М.Мөнхболор
7.	ТУЗ-ийн 2018 оны үйл ажиллагаа, компанийн засаглалын тайлан мэдээлэл	ТУЗ-ийн дарга Г.Хулан
8.	ТУЗ-ийн 2019 оны зардлын төсөв батлах.	ТУЗ-ийн дарга Г.Хулан
9.	Компанийн өрийг хувьцаагаар солих, түүнтэй холбоотойгоор хувьцаа нэмж гаргах	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар
10.	Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар
11.	Нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэх эсэх.	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар
12.	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох	Хурлын дарга Г.Хулан
13.	Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэртэй холбогдсон мэдээлэл	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар
14.	Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон ХЭ-ийн асуулт хариулт санал бодол	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар
15.	Завсарлага, санал тоолж нэгтгэх	Тооллогын комисс Х.Уянга
16.	Санал хураалтын дүнг хуралд танилцуулах /тооллогын комиссын тогтоол/	Тооллогын комисс Х.Уянга
17.	ХЭ-ийн хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулж батлуулах	ТУЗ-ийн н/б дарга Ө.Энхтайван
18.	Хурал хаах	Хурлын дарга Г.Хулан

ХУРЛЫН ТОВ: 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 13 цагаас

ХУРЛЫН БАЙР: “Улаанбаатар” зочид буудлын хурлын танхимд

### **ХУРАЛД ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах. Компанийн ТУЗ-ийн ажил, засаглалын талаарх мэдээлэл
2. Компанийн ТУЗ-ийн 2019 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах.
3. Компанийн өрийг хувьцаагаар солих, түүнтэй холбоотойгоор хувьцаа нэмж гаргах.
4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах
5. Нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэх эсэх
6. Компанийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
7. Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл





## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

1. - Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан танилцуулах  
Гүйцэтгэх захирал – Б.Батбаатар  
Ерөнхий инженер – Ж.Эрдэнэбат  
/10 минут/
  - Компанийн 2018 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитын тайлан  
Гүйцэтгэх захирал – Б.Батбаатар  
Санхүү эрхэлсэн дэд захирал– М.Мөнхболор  
Ерөнхий нягтлан бодогч-Л.Даваасүрэн  
/10 минут/
    - Компанийн ТУЗ-ийн ажил, засаглалын талаарх мэдээлэл  
ТУЗ-ийн дарга – Г.Хулан  
/10 минут/
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны цалин урамшуулал, зардлын төсөв  
ТУЗ-ийн дарга – Г.Хулан /5 минут/
3. - Компанийн өрийг хувьцаагаар солих, түүнтэй холбоотойгоор хувьцаа нэмж гаргах.  
-Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.  
  
-Нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэх эсэх  
Гүйцэтгэх захирал-Б.Батбаатар  
/цаг тоолохгүй/
4. Компанийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох  
/цаг тогтоохгүй/
5. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэртэй холбогдсон мэдээлэл  
Гүйцэтгэх захирал – Б.Батбаатар  
/5 минут/
6. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон асуулт хариулт  
/хүн тус бүр 3 минут/
7. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал, санамж  
/хүн тус бүр 4 минут/
8. Завсарлага, санал тоолж нэгтгэх  
Тооллогын комисс  
/15 минут/
9. Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоол танилцуулах  
Тооллогын комисс  
/цаг тогтоохгүй/
10. Хурлаас гарах шийдвэр /тогтоол/-ийг хэлэлцэж батлах  
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга –  
/цаг тогтоохгүй/

Хурлыг 4 цагт багтаана.

/Хэрэв шаардлагатай бол хуралдах хугацааг хэлэлцэн сунгаж болно/

Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2019 оны 4 сарын 26

дугаар 01

Улаанбаатар

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг  
хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 67.3.1; 67.3.8; 69.1 дэх заалтууд компанийн дүрмийн 7.4.1-ийн 9 дэх заалт, тооллогын комиссын гаргасан ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг бүртгэн нэгтгэсэн дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хуралд нийт 10`170`242 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг төлөөлж ..... ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа бүгд ..... хувь болсныг хуралд мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 4-ийн 7 дахь заалтын дагуу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны ..... хувийн эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН  
ДАРГА



Х.УЯНГА

**“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН /ХУРААНГУЙ/, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ, ТУЗ-ИЙН АЖИЛ БОЛОН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН**

**НЭГ. 2018 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**



**Ажиллах хүчний тухай үзүүлэлт**

- Ажилчдын тоо: Нийт 470 хүн  
 Үүнээс:
- Эрэгтэй –361
  - Эмэгтэй - 92
  - Удирдлага –17
  - Иженер техникийн ажилчид - 55
  - Ажилчид –388
  - ХММ-н оператор -79
  - Бульдозерын оператор -9
  - Грейдерийн оператор -3
  - Гидро-экскаваторын оператор -18
  - Экскаваторын машинч -17
  - Экскаваторын туслах машинч – 19
  - Ачигчийн оператор - 6



## Ажиллах хүчин , сургалт , шилжилт хөдөлгөөний үзүүлэлт

2018 оны сургалтын ажил			
Төрөл	Чиглэл	Тоон үзүүлэлт	Зардал /мян.төгрөг/
Гадны сургалт	Мэргэжлийн болон ХАБЭА-н чиглэлээр	10 удаа сургалт зохион байгуулсан	15,840.0
Дотоод сургалт	ХАБ, эрүүл мэнд, хууль эрх зүй болон мэргэшүүлэх чиглэлээр	95 удаагийн сургалтанд 2999 хүн хамрагдсан	





## ХАБЭАХ–ийн 2018 оны ажлын талаар

№	Хийж гүйцэтгэсэн ажлууд	х/н	Тоо хэмжээ	Тайлбар
1	ХАБЭА-н хугацаат аян , үйл ажиллагаа	удаа	10	17 сэдэвт аян өрнүүлж шалгаруулан 3.6 сая.төг-р урамшуулсан.
2	ХАБЭА-н сургалт	хүн	4090	Нийт ажилтны болон шинээр ажилд орсон болон ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалт
3	ХАБЭА-н үзлэг шалгалт	удаа	244	Ажлын байрны үзлэг 241 удаа , 3 шатны үзлэг 3 удаа хийгдсэн.
4	Анхааруулга мэдэгдэл	удаа	57	Бичгээр мэдэгдэл анхааруулга 39 удаа , аман анхааруулга 18 удаа өгсөн.
5	Үзлэг шалгалтанд хамрагдсан байдал	удаа	2	ДУА-н МХГ-н шалгалт , хяналтын 7 хуудасаар бага эрсдэлтэй , 1 хуудсаар дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. ДУА-н ОБГ-н шалгалтанд хангалттай үнэлэгдсэн.
6	Мэргэжлийн байгууллагын сургалтанд хамрагдсан байдал	удаа	6	ХАБЭА-н сургагч багш бэлтгэх , ХАБЭА-н ажилтан мэргэшүүлэх , ISO45001 стандартын сургалт , салбарын сургалт , ХЭА-н үндэс сургалт
7	ХАБЭА-н хурал	удаа	32	7 хоног бүрийн Баасан гаригт ХАБЭА-н ажлын тайлан мэдээллийг удирдлага , ажилтнуудад танилцуулдаг.
8	Шинээр хийсэн саибар, тэмдэг, санамж	удаа	97	Нийт үйлдвэрийн талбайд байршуулсан.
9	Эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байдал	удаа	63	Бүх хэсэг нэгжүүдэд хийгдсэн.
10	Аюулыг мэдээлэх хуудас	удаа	157	Мэдээллийн мөрөөр 144 аюулыг арилгасан.
11	Засаж сайжруулсан ажлууд	ш	8	Зам талбайн хашилт хамгаалалт , ажлын байрны нөхцөл сайжруулсан ажлууд хийгдсэн.
<b>Осол зөрчлийн тохиолдол</b>				
1	Үйлдвэрийн осол	удаа	1	Дүрмийн дагуу МХГ-т бүртгүүлж баталгаажуулсан.
2	Осолд дөхсөн тохиолдол	удаа	1	Холбогдох журмын дагуу судлан бүртгэж , хариу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.
3	Хөнгөн гэмтэл	удаа	5	
4	Өмчийн эвдрэлийн тохиолдол	удаа	6	



**Байгаль орчин хамгаалал нөхөн сэргээлтийн ажил**

№	Үзүүдэлт	Тоо хэмжээ	
1	Хэмжээг есгүлжнээ Ш	Агаар	4
		Ус	4
		Хөрс	4
		Цацраг	2
2	Сургаалт / асгаралт, цацраг/	172 ажилтан	
3	Үзлэг хяналт	34 удаа	
4	Албан мэдэгдэл	29 удаа	
5	Нөхөн сэргээлт	5.0 га, 1.212 м3	
6	Орчны цэвэрлэгээ	ШГХК-д 2 удаа, суманд 1 удаа	
7	Ногоон бүс байгуулалт	Уурхайд 0.3 га зүлэг, сумын төвд 100 гаруй мод тарьсан.	




**2018 оны хөрс хуулалт, нүүрс олборлолтын гүйцэтгэл**

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 он	2018 он		2018 оны төлөвлөгөөний биелэлт ( %)
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Нүүрс олборлолт	м.тн	912.3	1063.8	1089.4	102.41
2	Нүүрс борлуулалт	м.тн	909.3	1040.2	1076.8	103.52
3	Хөрс хуулалт	м.м <sup>3</sup>	4660.7	9132	5884.1	64.43
4	Тээвэртэй	м.м <sup>3</sup>	4170.1	8412	5851.4	69.56
5	Тээвэргүй	м.м <sup>3</sup>	490.6	720	32.7	4.54
6	Уулын цул	м.м <sup>3</sup>	5362.5	9950.3	6722.1	67.56
7	Шидэлт	м.м <sup>3</sup>	364.7	0	260.3	-
8	Өрөмдлөг	м.у.м	67.7	89.1	73.1	82.04
9	Х.Х.Коэффициент	м <sup>3</sup> /тн	5.1	8.6	5.4	62.92



**2018 оны хөрс хуулалт, нүүрс олборлолтын гүйцэтгэлийн талбайн зураг**



**Төвийн хойд блок**  
 Хөрс төл. 2820.0 м.м3 гүй. 1679.8 м.м3  
 Нүүрс төл. 0 м.тн гүй. 83.3 м.тн

**Хойд блок гарш**  
 Хөрс төл. 55.0 м.м3 гүй. 108.4 м.м3  
 Нүүрс төл. 55.3 м.тн гүй. 79.8 м.тн  
 Илчлэг чанар

**Хойд блок**  
 Хөрс төл. 4920.0 м.м3 гүй. 1813.7 м.м3  
 Нүүрс төл. 559.7 м.тн гүй. 332.1 м.тн  
 Илчлэг чанар 3976.1 ккал

**Төвийн урд блок**  
 Хөрс төл. 1297.0 м.м3 гүй. 1628.6 м.м3  
 Нүүрс төл. 447.2 м.тн гүй. 569.9 м.тн  
 Илчлэг чанар 4031.1 ккал

**Өмнөд блок**  
 Хөрс төл. 0 м.м3 гүй. 653.6 м.м3  
 Нүүрс төл. 0 м.тн гүй. 24.3 м.тн



## 2019.01.01-ний байдлаар уурхайн нүүрсний геологийн нөөц

2019.01.01 - ны байдлаар нөөц								
Нүүрс блокуудын нөөц /тн/								
SG	sout floor	Remnant	Graveyard Ext	Graveyard	South Hight Wall	North Hight Wall	North floor	Нийт
POP Блок	15B, 25B, 24B, 20B, 19B, 23B, 22B, 21B, 13C, 19C, 21C, 22C, 24C, 25C	29B, 7C, 22C, 23C, 24C	5C, 27B, 18B, 26B, 28B, 17B, 6C, 19C, 22C	5B, 4B, 6B, 1A, 7B, 9B, 8B, 4C, 16B, 18C, 19C,	14B, 19B, 20B, 21B, 22B, 32B, 33B, 13C, 34B, 11B, 3A, 31B, 15C, 14C, 20C, 24C, 34B	1C, 2C, 1B, 2B, 3B, 3C, 12B, 13B, 8C, 9C, 10C, 2A, 11C, 12C, 30B	2B, 3B, 3C, 10B, 11B, 16C, 17C, 19C	
Цэвэр	1488,530.0	1157,490.0	4825,820.0	4501,090.0	5787,830.0	4500,700.0	3735,360.0	25996,820.0
Бохир	1633,250.0	1251,180.0	5207,480.0	4975,760.0	6285,730.0	4717,690.0	3982,280.0	28053,370.0
Нүүрс олборлолт /тн/								
2013	323,351.4	109,977.1	295,722.5	9,706.3				738,757.2
2014	125,600.0	255,000.0	5,900.0	245,500.0	19,100.0		98,500.0	749,600.0
2015		84,500.0	41,900.0	209,600.0	374,400.0		47,900.0	758,300.0
2016		101,900.0	102,000.0		551,000.0		7,000.0	761,900.0
2017			335,162.2		577,111.0			912,273.2
2018	-	24,271.9	79,874.6	332,088.4	653,148.3	-	-	1089,383.1
2019 он 1		48,000.0			3,390.0	116,220.0		167,610.0
2019	-	48,000.0	-	-	3,390.0	116,220.0	-	167,610.0
Нийлбэр	448,951.39	623,649.02	860,559.25	796,894.62	2178,149.25	116,220.00	153,400.00	5177,823.53
Үлдэгдэл	1184,298.61	627,530.98	4346,920.75	4178,865.38	4107,580.75	4601,470.00	3828,880.00	22875,546.47




### Борлуулалтын үйл ажиллагааны үзүүлэлт

№	Харилцагч	2017 он		2018 он		Өөрчилөлт		
		дундаж үнэ	тонн	дундаж үнэ	тонн	тонн	тонн %	Үнийн дүн %
1	Эрчим хүч	36,506	652,383	37,086	1,008,966	356,583	54.66%	57.11%
2	VIP	54,584	218,735	54,021	24,901	-193,834	-88.62%	-88.73%
3	Гэрээт: ЖДҮ	47,251	27,119	50,749	34,216	7,097	26.17%	35.51%


Станцуудын борлуулалтын гүйцэтгэл тн-р



Борлуулалтын гүйцэтгэл %-р



Сарын төлөвлөгөөний биелэлт %-р





## ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДСЭН ХЭРЭГЛЭГЧДЭД 2018 ОНД ИЙЛҮҮЛСЭН НҮҮРСНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

2018 онд ГОК-д нийлүүлсэн нүүрсний шинжилгээний дүн				
I Улирал	27.0	14.6	43.3	3986.6
II Улирал	25.1	16.0	41.9	3986.2
III Улирал	27.4	17.0	42.5	3719.1
IV Улирал	26.4	16.2	42.7	3895.9
<b>ДҮН</b>	<b>26.5</b>	<b>15.9</b>	<b>42.6</b>	<b>3897.0</b>


### 2018 онд Эрдэнэтийн дулааны цахилгаан станцад нийлүүлсэн нүүрсний шинжилгээний дүн

Огноо	Чийглэг %		Үнслэг %		Дэгдэмхий %		Дулаан гаргах чадвар ккал/кг	
	W <sup>a</sup>	W <sup>p</sup>	A <sup>a</sup>	A <sup>p</sup>	V <sup>a</sup>	V <sup>a</sup>	Qb <sup>a</sup>	Qn <sup>p</sup>
I Улирал	1.9	16.3	31.0	26.5	29.1	43.6	4792.3	3787.9
II Улирал	1.9	14.5	32.3	28.2	28.4	43.5	4604.9	3731.7
III Улирал	1.7	15.4	34.2	29.4	27.7	43.4	4502.3	3584.5
IV Улирал	1.9	14.8	32.4	28.3	27.9	43.0	4646.5	3732.5
<b>ДҮН</b>	<b>1.9</b>	<b>15.2</b>	<b>32.5</b>	<b>28.1</b>	<b>28.3</b>	<b>43.4</b>	<b>4636.5</b>	<b>3709.1</b>

### 2018 онд Дарханы дулааны цахилгаан станцад нийлүүлсэн нүүрсний шинжилгээний дүн


Огноо	Чийглэг %		Үнслэг %		Дэгдэмхий %		Дулаан гаргах чадвар ккал/кг	
	W <sup>a</sup>	W <sup>p</sup>	A <sup>a</sup>	A <sup>p</sup>	V <sup>a</sup>	V <sup>a</sup>	Qb <sup>a</sup>	Qn <sup>p</sup>
I Улирал	1.9	15.8	32.7	28.1	28.0	42.9	4574.9	3691.6
II Улирал	2.4	15.8	30.8	26.7	28.0	42.0	4703.9	3766.0
III Улирал	2.2	16.9	34.0	29.0	27.1	42.5	4431.6	3470.1
IV Улирал	2.0	15.8	31.7	28.7	27.1	42.0	4437.0	3673.3
<b>ДҮН</b>	<b>2.1</b>	<b>16.1</b>	<b>32.3</b>	<b>28.1</b>	<b>27.5</b>	<b>42.3</b>	<b>4536.9</b>	<b>3650.2</b>

## Хөрс хуулалт, нүүрс олборлолтын гүйцэтгэлийн үзүүлэлт сараар



Блок	2017		2018	
	Гүйцэтгэл		Гүйцэтгэл	
	Нүүрс	Хөрс	Нүүрс	Хөрс
Өмнөд блок	-	-	24.3	653.6
Хойд блок	-	860.9	332.1	1813.7
Хойд блок гарш	335.2	682.1	79.8	108.4
Төвийн урд блок	577.1	3133.1	569.9	1628.6
Төвийн хойд блок	-	-	83.3	1679.8
<b>НИЙТ ДҮН</b>	<b>912.3</b>	<b>4676.1</b>	<b>1089.4</b>	<b>5884,1</b>
<b>XXКoeffициент</b>	<b>5.13</b>		<b>5.40</b>	

## 2018 оны хөрс нүүрсний үзүүлэлт нийт техникийн төрлөөр






## 2018 онд ачсан хөрс нүүрсний үзүүлэлт экскаваторын төрлөөр




## 2018 онд тээвэрлэсэн хөрс нүүрсний үзүүлэлт техникийн төрлөөр

### УУЛЫН БҮТЭЭЛ МАШИНЫ ТӨРЛӨӨР





### 2018 оны техникийн цаг ашиглалтын үзүүлэлт / коэффициентээр/






## 2018 оны тэсэлгээний ажлын өртөг, зарцуулалтын үзүүлэлт




Сар	Тэсэлсэн уулын цулын гүйцэтгэл /мян.м3/	Амфо /тн/			Эмульс ф120 /тн/		
		төлөв	гүйц	зөрүү	төлөв	гүйц	зөрүү
Нийт	1,341	544.0	319.368	(224.93)	365.0	402.59	38.41


2017 ОНД ТЕХНИКИЙН БЭЛЭН БАЙДАЛ 85,5 % / төрлөөр /



2018 ОНД ТЕХНИКИЙН БЭЛЭН БАЙДАЛ 86,6 % / төрлөөр /



**Уулын үндсэн техникүүдийн бэлэн байдлын үзүүлэлтийг төлөвлөгөөтэй харьцуулсан график**



## Цахилгаан эрчим хүч зарцуулалтын үзүүлэлт

### Эрчим хүчний тариф

Мөрдсөн хугацаа	Ангилал	Тариф /төг/квтц/
2015.07.06-2017.07.17 хүртэл	Өдрийн хэрэглээ	06.00 - 17.00 155.90
	Оройн хэрэглээ	17.00 - 22.00 276.00
	Шөнийн хэрэглээ	22.00 - 06.00 77.10
2017.07.17-2018 дуустал мөрдсөн	Өдрийн хэрэглээ	06.00 - 17.00 167.78
	Оройн хэрэглээ	17.00 - 22.00 287.88
	Шөнийн хэрэглээ	22.00 - 06.00 88.98

2016он төлөвлөгөө мян.квтцаг	2016он гүйцэтгэл мян.квтцаг	2017он төлөвлөгөө мян.квтцаг	2017он гүйцэтгэл мян.квтцаг	2018он төлөвлөгөө мян.квтцаг	2018он гүйцэтгэл мян.квтцаг
7586.0	7849.76	8664.0	7667.54	8195.0	6272.5



Д/Д	Хэсэг/техник	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Экскаватор 28	Квт.цаг	116,051.36
2	Экскаватор 37	Квт.цаг	534,038.20
3	Экскаватор 38	Квт.цаг	470,186.00
4	Экскаватор 39	Квт.цаг	319,783.40
5	Экскаватор 42	Квт.цаг	356,682.90
6	Экскаватор 36	Квт.цаг	8,291.85
7	УША	Квт.цаг	474,265.79
8	ГУШХ	Квт.цаг	1,365,913.89
9	НААХ	Квт.цаг	641,148.63
10	Экс 20	Квт.цаг	52,944.00
11	Төмөр зам	Квт.цаг	3,058.00
12	МЗХ	Квт.цаг	138,103.74
13	ТТЗГ	Квт.цаг	263,770.20
14	ЦШС	Квт.цаг	131,576.30
15	Лаборатори	Квт.цаг	11,730.80
16	ШТС	Квт.цаг	23,763.00
17	Харуул	Квт.цаг	80,037.10
18	Ү.Эмнэлэг	Квт.цаг	23,255.51
19	НБУ	Квт.цаг	8,160.20
20	ҮАГ	Квт.цаг	12,456.65
	Ү.комбинат	Квт.цаг	31,140.21
<b>ИЙТ ДҮН:</b>			<b>5,066,357.73</b>



## ХОЁР. 2018 ОНЫ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН /ХУРААНГУЙ/



Tel: +976 77404040  
Fax: +976 77404041  
www.bdo.mn  
Zip code: 14230 0059

Room 1502, Level 15  
Union Building - B, Unesco Street  
Narmii Zam - 62, Khoroо - 1  
Sulhiibaatar District, Ulaanbaatar  
Mongolia

Утас: +976 77404040  
Факс: +976 77404041  
www.bdo.mn  
ШНХ: 14230-0059

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
1-р хороо, Нарны зам - 62, ЮНЕСКО-ийн  
гудамж, ЮНИОН БЮЛДИНГ 6 блок  
15 -р давхар, 1502 тоот

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### “Шарын Гол” ХК-ийн Хувьцаа эзэмшигчид

#### Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

#### Санал дүгнэлт

Бид “Шарын гол” ХК болон түүний охин компаниудын (нийтэд нь “Групп” гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2018 оны 12 сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийг томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь группийн 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЭЗОУСЗ”)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байсан бөгөөд НБЭЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

#### Өөдрөг төсөөлөлтэй холбоотой материаллаг тодорхой бус байдал

Групп Тэмдэглэл 2-д дурдсанчлан тасралтгүй ажиллагааны төсөөлөлд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэсэн. Удирдлага үйл ажиллагааг зогсоох бодитой төлөвлөгөөтэй, эсвэл үүнээс өөр аргагүй бодитой нөхцөл үүсэхээс бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн энэхүү суурийг ашигладаг. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад бид удирдлагын тасралтгүй ажиллагааны суурь ашигласан нь буруу биш гэж дүгнэсэн.

Гэхдээ, 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группийн эргэлтийн өр төлбөр нь эргэлтийн хөрөнгийн дүнгээс 14 тэрбум төгрөгөөр давсан бөгөөд хөрөнгийн дутагдлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байгаа нь тасралтгүй үйл ажиллагааны төсөөлөл хэрэгжих эсэхэд тодорхой эргэлзээ үүсгэж байна. Группийн удирдлага болон хөрөнгө оруулагчийн зүгээс энэхүү дутагдлыг шийдвэрлэх бодитой алхам хийж байна.

Хэдийгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг тасралтгүй ажиллагааны төсөөлөлд суурилан бэлтгэсэн боловч группийн удирдлага ч, аудитор ч группийн тасралтгүй үйл ажиллагааг батлан дааж чадахгүй.





## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Асуудлыг онцлох нь

Тэмдэглэл 38 Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага хэсгийг нэгтгэсэн санхүүгийн тайлан хэрэглэгчид анхааралтай авч үзвэл зохино. Бид Группийн Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага холбоотой асуудлаар дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

### Аудитын гол асуудлууд

#### 1. Уурхайн хөрөнгийн дансны үнэ ба олборлолтын өртөг

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 17,689,834 мянган төгрөгийн дансны үнэ бүхий уурхайн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилт нь Тэмдэглэл 5(h)- д тодорхойлсон шийдлийг удирдлагаас шаарддаг. Групп нь бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргыг ашигладаг бөгөөд уурхайн нийт нөөцийг тодорхойлох болон уурхайн хөрөнгийг үйлдвэрлэлийн нэгжид хуваарилахтай холбоотой шийдлүүд гаргадаг.

#### 2. Зээл

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар группийн нийт өр төлбөрийн 31%-ийг зээлийн өр төлбөр эзэлж байна. Мөн нийт хөрөнгийн 69%-ийг зээлийн өр төлбөр эзэлж байна. Зээлийн хэмжээ болон капиталын бүтэц дэх өсөлт нь аудитын гол асуудлууд болно

#### 3. Нөхөн сэргээлтийн сангийн нөөц

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группийн нөхөн сэргээлтийн сангийн үлдэгдэл нь 10,513,072 млн.төгрөг байсан. Группийн нөхөн сэргээлтийн нөөц нь Тэмдэглэл 30-д тусгагдсан. Түүнчлэн 4(h)- д тодорхойлсон шийдлийг удирдлагаас шаарддаг. Нөөцийг тодорхойлоход мөнгөний урсгал, зохистой дискаунтын түвшин зэрэг шаардлагатай ажлыг гүйцэтгэхэд удирдлагын үнэлэмж хэрэгтэй байдаг.

#### Аудитын хариу

Бид 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх хүдрийн агууламж, түвшин болон нягтралын талаарх мэдээллийг ТЭЗҮ дэх мэдээлэлтэй тулгаж шалгасан. ТЭЗҮ боловсруулахад удирдлагын ашигласан өгөгдлүүд мэргэжлийн үр чадвар болон бодитой байдлыг үнэлсэн. Тайлант жилийн турш капиталуулсан зарцуулалтуудын дэлгэрэнгүй тест гүйцэтгэж, тухайн зарцуулалтуудын үнэн зөв, иж бүрэн байдлыг үнэлсэн. Мөн бид цэвэр боломжит үнэ цэнийн тесттэй холбоотойгоор ирээдүйн нүүрсний үнэ болон одоогийн нүүрсний үнийг харьцуулж, зах зээлийн хандлагыг харгалзан үзсэн. Мөн уурхайн хөрөнгөтэй холбоотой үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрхийлсэн аливаа зүйл байхгүй талаарх удирдлагын үнэлгээг чухалчлан авч үзсэн.

#### Аудитын хариу

Бид группийн зээл авсан банкуудаас зээлийн дүн, нөхцөл, хугацаа болон бусад нөхцөлийг баталгаажуулсан. Мөн бид зээлийн гэрээний шаардлагууд болон санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуулсан. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 28-д зээлийн гэрээний талаарх группийн тодруулгыг үнэлсэн.

#### Аудитын хариу

Бид ирээдүйн зардлын төлөвлөгөө, өртгийн загварыг бэлтгэхэд удирдлагын ашигласан мэргэжлийн үр чадвар, бодитой байдлыг үнэлсэн. Бид уурхайн зардлын төлөвлөгөө, зардлын загварчлалыг үнэлсэн бөгөөд уг загварчлал дахь гол тооцоолол болон төсвийн үнэлсэн. Түүнчлэн бид нөхөн сэргээлтийн хүлээгдэж буй хугацааг уурхайн ашиглалтын хугацаанд тооцоолж, хүлээгдэж байгаа мөнгөн урсгалд ашигласан дискаунтын түвшинг үнэлсэн.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцэлтийг авч үзэхэд оршдог.

Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

### Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм үү заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юм үү үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөлөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг тооцогддог.





## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага(үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажигладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлож, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашгт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон хялбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамгайд мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлож, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 95.1-р зүйлд заасан дагуу зөвхөн "Шарын Гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



**Д.АЛТАНСУХ**  
БДО Аудит ХХК  
Монгол улс, Улаанбаатар хот  
СБД-1, ЮНЕСКО гудамж, Нарны зам-62  
ЮНИОН Бюдинг В блок, 1502 тоот өрөө

Огноо: 2019.04.04



**“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН  
ТАЙЛАН**

	Тэм	Групп		Компани	
		2018 он млн.төг	2017 он млн.төг	2018 он млн.төг	2017 он млн.төг
Борлуулалтын орлого	8	48,687,562	48,875,033	48,687,562	48,847,101
Борлуулалтын өртөг	9	(40,674,974)	(39,184,502)	(41,564,233)	(38,954,315)
<b>Нийт ашиг</b>		<b>8,012,588</b>	<b>9,690,531</b>	<b>7,123,329</b>	<b>9,892,786</b>
Ерөнхий ба удирдлагын зардал	10	(3,223,697)	(2,965,659)	(2,800,812)	(2,626,409)
Борлуулалт, маркетингийн зардал	11	(252,587)	(404,138)	(252,587)	(404,138)
<b>Үйл ажиллагааны ашиг</b>		<b>4,536,304</b>	<b>6,320,734</b>	<b>4,069,930</b>	<b>6,862,238</b>
Санхүүгийн орлого	12	336,383	2,463,497	315,718	2,454,759
Санхүүгийн зардал	13	(5,278,077)	(4,408,628)	(4,899,927)	(4,178,902)
Бусад орлого	14	208,586	130,608	208,461	130,608
Бусад зардал	15	(4,183,824)	(1,262,158)	(4,177,637)	(1,239,526)
Бусад олз/(гарз)	16	4,298,447	(11,956)	40,686	(11,956)
<b>Татварын өмнөх ашиг(алдагдал)</b>		<b>(82,181)</b>	<b>3,232,097</b>	<b>(4,442,769)</b>	<b>4,017,221</b>
Орлогын албан татварын (зардал)/өгөөж	17	121,143	(886,735)	190,148	(886,432)
<b>Татварын дараах цэвэр ашиг/(алдагдал)</b>		<b>38,962</b>	<b>2,345,362</b>	<b>(4,252,621)</b>	<b>3,130,789</b>
<b>Татварын жилийн ашиг/(алдагдал)</b>					
Хувьцаа эзэмшигчдэд ногдох		(101,325)	2,415,791	(4,252,620)	3,130,789
Хяналтын бус багц эзэмшигчид ногдох		140,287	(70,429)	-	-
		<b>38,962</b>	<b>2,345,362</b>	<b>(4,252,620)</b>	<b>3,130,789</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлогын тайлан:</b>					
Дахин үнэлгээний нэмэгдэл		-	31,012	-	31,012
Дахин үнэлгээний нооцийн бууралт		413,769	(17,476)	413,769	(17,476)
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй</b>		<b>452,731</b>	<b>2,358,898</b>	<b>(3,838,851)</b>	<b>3,144,325</b>
Хувьцаа эзэмшигчид		312,444	2,429,327	(3,838,852)	3,144,325
Хяналтын бус багц эзэмшигчид		140,287	(70,429)	-	-
		<b>452,731</b>	<b>2,358,898</b>	<b>(3,838,852)</b>	<b>3,144,325</b>
Нэгж энгийн хувьцаанд ногдох үндсэн болон хорогдуулсан ашиг(алдагдал) төгрөг	18	(9.96)	237.54	(418.14)	307.84

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх  
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

	Тэм	Групп		Компани	
		2018 он млн.төг	2017 он млн.төг	2018 он млн.төг	2017 он млн.төг
<b>ХӨРӨНГӨ</b>					
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>					
Өмч, Барилга, Тоног төхөөрөмж	19	41,391,465	38,202,509	40,693,312	35,763,345
Биег бус хөрөнгө	20	89,185	23,676	88,879	22,214
Уурхайн хөрөнгө	21	17,689,834	19,210,960	17,689,834	19,210,960
Урт хугацаат хөрөнгө оруулалт	7, 22	453,644.00	-	878,644	2,209,830
Хойшлогдсон татварын хөрөнгө	17	537,521	73,062	537,521	62,957
Гүүдмил	7	424,990	424,990	-	-
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>		<b>60,586,639</b>	<b>57,935,197</b>	<b>59,888,190</b>	<b>57,269,306</b>
<b>Эргэлтийн хөрөнгө</b>					
Бараа материал	23	2,698,644	2,454,417	2,698,644	2,424,576
Урьдчилж төлсөн зардал ба бусад эргэлтийн хөрөнгө	24	386,665	1,133,409	386,665	1,023,542
Худалдааны ба бусад авлага	25	2,150,356	6,011,414	1,899,848	8,198,376
Мөнгөн хөрөнгө	26	3,164,364	900,181	3,161,849	849,614
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>		<b>8,400,029</b>	<b>10,499,421</b>	<b>8,147,006</b>	<b>12,496,108</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>68,986,668</b>	<b>68,434,618</b>	<b>68,035,196</b>	<b>69,765,414</b>
<b>ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>					
<b>Өмч</b>					
Хувьцаат капитал	27	1,017,024	1,017,024	1,017,024	1,017,024
Нэмж төлөгдсөн капитал	27	23,145,158	23,145,158	23,145,158	23,145,158
Дахин үнэлгээний нэмэгдэл	27	9,632,468	10,046,237	9,632,468	10,046,237
Хуримтлагдсан алдагдал		(12,686,876)	(12,999,320)	(13,169,405)	(9,330,553)
<b>Нийт өмч</b>		<b>21,107,774</b>	<b>21,209,099</b>	<b>20,625,245</b>	<b>24,877,866</b>
Хяналтын бус багц эзэмшигчид		-	(140,287)	-	-
<b>НИЙТ ӨМЧ</b>		<b>21,107,774</b>	<b>21,068,812</b>	<b>20,625,245</b>	<b>24,877,866</b>
<b>Өр төлбөр</b>					
<b>Эргэлтийн бус өр төлбөр</b>					
Урт хугацаат зээл	28	8,398,477	12,135,650	8,398,477	12,135,650
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	29	1,808,277	-	1,808,277	-
Урт хугацаат зээлийн хүүгийн өглөг	28	1,882,795	-	1,882,795	-
Сангууд	30	12,790,783	12,564,883	12,790,783	12,564,883
<b>Нийт урт хугацаат өр</b>		<b>24,880,332</b>	<b>24,700,533</b>	<b>24,880,332</b>	<b>24,700,533</b>

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**

2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (үргэлжлэл)**

	Тэм	Групп		Компани	
		2018 он млн.төг	2017 он млн.төг	2018 он млн.төг	2017 он млн.төг
<b>Эргэлтийн өр төлбөр</b>					
Урт хугацаат зээлийн богино хугацаанд хамаарагдах хэсэг	28	-	338,359	-	-
Богино хугацаат зээл	28	5,838,593	4,243,461	5,838,593	3,151,628
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	29	3,890,306	3,506,862	3,890,306	3,506,862
Хүүгийн өглөг	28, 29	817,431	5,542,227	817,431	4,892,030
Хураамжийн өглөг	28	120,742	146,616	120,742	146,616
Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн өглөг	28	-	33,987	-	-
Худалдааны ба бусад өглөг	31	9,143,592	8,152,051	8,734,774	7,789,599
Гэрээний өр төлбөр	32	2,356,410	20,560	2,356,410	20,560
Татварын өглөг	33	831,488	681,151	771,363	679,720
<b>Нийт эргэлтийн өр төлбөр</b>		<b>22,998,562</b>	<b>22,665,273</b>	<b>22,529,619</b>	<b>20,187,015</b>
<b>Нийт өр төлбөр</b>		<b>47,878,894</b>	<b>47,365,806</b>	<b>47,409,951</b>	<b>44,887,547</b>
<b>НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>		<b>68,986,668</b>	<b>68,434,618</b>	<b>68,035,196</b>	<b>69,765,414</b>

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.



**“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	Тэм	Групп		Компани	
		2018 он төгрөг	2017 он төгрөг	2018 он мян.төг	2017 он мян.төг
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>					
<i>Татварын өмнөх ашиг/(алдагдал)</i>		<b>(82,182)</b>	<b>3,232,097</b>	<b>(4,442,769)</b>	<b>4,017,222</b>
<b>Тахируулга:</b>					
<i>Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол болон шавхагдал</i>	19,20, 21	7,690,567	6,998,182	7,518,673	6,896,176
<i>Өмч, барилга, тоног төхөөрөмж данснаас хассаны гарз</i>	19	284,097	11,956	284,097	11,956
<i>Бараа материалын үнэ цэнийн бууралт гарз</i>	16	(953,708)	-	(953,708)	-
<i>Өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулалтын (алз)/гарз</i>	16	322,800	-	322,800	-
<i>Охин компанийн хувьцаа борлуулсны гарз</i>	16	115,956	-	115,956	-
<i>Өмч, барилга, тоног төхөөрөмж үнэ цэнийн бууралтын гарз</i>	16	175,906	-	175,906	-
<i>Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт</i>	16	14,263	-	14,263	-
<i>Хөрс хуулалтын хөрөнгийн хэрэгжилт</i>	21	-	2,704,117	-	2,704,117
<i>Уурхайн нөхөн сэргээлтийн сангийн нэмэгдэл</i>	13	14,005	755,162	14,005	755,162
<i>Ажилчдын тэтгэврийн сангийн зардал</i>	9, 10, 11	921,234	186,363	921,234	186,363
<i>Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн өр</i>	12, 13	-	(1,185,867)	-	(1,185,867)
<i>Найдваргүй авлагын зардал</i>	15	2,721,454	49,452	2,721,454	49,452
<i>Хүү болон зээлийн хураамжийн зардал</i>	13	3,123,460	2,750,398	2,916,423	2,550,284
<i>Хүүгийн орлого</i>	12	(51,905)	(18,384)	(43,237)	(18,384)
<i>Валютын ханшийн бодит бус гарз(алз)</i>	12, 13	1,962,912	(658,180)	1,819,084	(686,267)
<b>Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг</b>		<b>16,258,859</b>	<b>14,825,295</b>	<b>11,384,181</b>	<b>15,280,214</b>
<b>Ажлын капиталын өөрчлөлт:</b>					
<i>Бараа материалын (өсөлт)/бууралт</i>	23	(4,546,093)	(117,384)	(288,331)	(264,496)
<i>Худалдааны болон бусад авлагын (өсөлт)/бууралт</i>	24, 25	1,756,548	(73,742)	4,252,577	(399,995)
<i>Худалдааны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт)</i>	31	3,179,802	82,292	581,984	62,465
<i>Гэрээний хөрөнгийн (өсөлт)/бууралт</i>	32	2,335,851	-	2,335,851	-
<b>Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн урсгал</b>		<b>18,984,967</b>	<b>14,716,461</b>	<b>18,266,262</b>	<b>14,678,188</b>
<i>Төлсөн орлогын татвар</i>	33	(500,000)	(100,000)	(500,000)	(100,000)
<i>Хүүгийн төлөлт</i>	28	(4,476,907)	(1,500,686)	(4,476,907)	(1,500,686)
<i>Хүлээн авсан хүү</i>	13	51,905	18,384	43,237	18,384
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>14,059,965</b>	<b>13,134,159</b>	<b>13,332,592</b>	<b>13,095,886</b>

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.



**“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (үргэлжлэл)**

	Тэм	Групп		Компани	
		2018 он төгрөг	2017 он төгрөг	2018 он млн.төг	2017 он млн.төг
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>					
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	22	832,480	-	832,480	-
Дуусаагүй барилгын нэмэгдсэн өртөг	19	(13,636)	(1,286)	(13,636)	(1,286)
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн худалдан авалт	19	(6,879,863)	(4,106,738)	(6,108,038)	(4,116,161)
Бичиг бус хөрөнгийн худалдан авалт	20	(89,617)	(660)	(89,617)	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(6,150,636)</b>	<b>(4,108,684)</b>	<b>(5,378,811)</b>	<b>(4,117,447)</b>
<b>САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>					
Хүлээн авсан зээл	28	8,253,869	-	8,253,869	-
Эргэн төлсөн зээл	28	(10,499,172)	(6,067,725)	(10,499,172)	(6,067,725)
Санхүүгийн түрээсийн буцаалт орж ирсэн мөнгө		622,686	-	622,686	-
Санхүүгийн түрээсийн төлбөр	29	(3,925,753)	(2,839,571)	(3,925,753)	(2,839,571)
<b>Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(5,548,370)</b>	<b>(8,907,296)</b>	<b>(5,548,370)</b>	<b>(8,907,296)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр(бууралт)/өсөлт</b>		<b>2,264,650</b>	<b>112,673</b>	<b>2,312,235</b>	<b>65,643</b>
<i>Гадаад валютын ханшийн зөрүү</i>					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		(96,309)	(5,507)	(93,176)	(5,501)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26	900,181	787,508	849,614	397,686
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26	3,164,831	900,181	3,161,849	783,972
<b>Хөрөнгө оруулалт ба санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээний нэмэлт тодруулга</b>					
Охин компанийг борлуулсны гарз(олз)		(4,257,761)	-	-	-
Санхүүгийн түрээсээр авсан Өмч, барилга, тоног төхөөрөмж		(7,583,433)	2,844,953	(7,583,433)	2,844,953
Санхүүгийн түрээсийн тоног төхөөрөмжийн худалдан авалтын буцаалт		(1,995,480)	-	(1,995,480)	-
Хөрс хуулалтын хөрөнгийн буцаалт		-	2,704,117	-	2,704,117
Уурхайн хөрөнгөнд капиталжуулсан нөхөн сэргээлтийн сангийн өөрчлөлт	30	994,856	(2,504,872)	994,856	(2,504,872)
Дахин үнэлгээний нэмэгдэл	19, 27	-	31,012	-	31,012
Дахин үнэлгээний хэрэгжилт	19, 27	(413,769)	(17,476)	(413,769)	(17,476)

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
НЭГТЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН**

Группийн түвшинд	Тэм	Хувьцаат		Дажин		Хуримтлагдсан ашиг/(өлдөгдөл)	Нийт	Хяналтын бүс багц		Нийт
		капитал	урамшуулал	уналганый нэмэгдэл	нэмэгдэл			бүс багц	Мин.төг	
<b>2017 оны 01 сарын 01-ний өдрөөрх үлдэгдэл</b>		1,017,024	23,145,158	10,032,702	-	(15,432,588)	18,762,296	(69,859)	18,692,437	
Тайлант үеийн цаар алдагдал		-	-	-	-	2,415,791	2,415,791	(70,429)	2,345,362	
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	27	-	-	13,535	-	17,477	31,012	-	31,012	
<b>2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл</b>		<b>1,017,024</b>	<b>23,145,158</b>	<b>10,046,237</b>	<b>-</b>	<b>(12,999,320)</b>	<b>21,209,099</b>	<b>(140,288)</b>	<b>21,068,811</b>	
Тайлант үеийн цаар ашиг		-	-	-	-	(101,325)	(101,325)	140,287	38,962	
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	27	-	-	(413,769)	-	413,769	-	-	-	
<b>2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл</b>		<b>1,017,024</b>	<b>23,145,158</b>	<b>9,632,468</b>	<b>-</b>	<b>(12,686,876)</b>	<b>21,107,774</b>	<b>-</b>	<b>21,107,774</b>	

16-77-р хуудсан дахь тэмдэглэлгүй нь явзаар санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**
**2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

Компанийн түшигц	Тэм	Хувьцаат	Хувьцааны	Дахин	Хуримтлагдсан	Нийт
		капитал	урамшуулал	унэлгэний	ашиг/(алдагдал)	
		млн.төг	млн.төг	нэмэгдэл	млн.төг	млн.төг
<b>2017 оны 01 сарын 01-ний өдрөөрх үлдэгдэл</b>		<b>1,017,024</b>	<b>23,145,158</b>	<b>10,032,701</b>	<b>(12,476,818)</b>	<b>21,716,065</b>
Тайлант үеийн цэвэр алдагдал		-	-	-	3,130,789	3,130,789
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	27	-	-	13,536	17,476	31,012
<b>2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл</b>		<b>1,017,024</b>	<b>23,145,158</b>	<b>10,046,237</b>	<b>(9,330,554)</b>	<b>24,877,865</b>
Тайлант үеийн цэвэр ашиг		-	-	-	(4,252,620)	(4,252,620)
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	27	-	-	(413,769)	413,769	-
<b>2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл</b>		<b>1,017,024</b>	<b>23,145,158</b>	<b>9,632,468</b>	<b>(13,169,405)</b>	<b>20,625,245</b>

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлануудын салшгүй хэсэг болно.



## **ГУРАВ. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

Хамтын удирдлага болох компанийн ТУЗ нь компанийн ойрын болон хэтийн бодлогыг тодорхойлж, компанид үр ашигтай шийдвэр гаргах, үйл ажиллагааг нь хянах, хууль тогтоомжийн хэрэгжилт, гэрээ хэлцлүүдэд удирдамж зөвлөмжөөр ханган, компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагааг явуулж ирлээ.

### **⇒ 2018 оны засаглалын төлөвлөлт**

Тус компани, түүний төлөөлөн удирдах зөвлөл, 2018 онд компанийн засаглалын зарчмуудын дагуу доорхи төлөвлөгөөг боловсруулан батлаж түүнийг мөрдлөг болгон ажилласан. Үүнд:

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны хурлаар хэлэлцэх үндсэн асуудлын төлөвлөгөө
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны мэдээлэл, үйл явдлын хуанли
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод /аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороо/-ын 2018 оны ажлын төлөвлөгөө
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан хийх ажил цаг хугацааны график
- Компанийн 2018 оны сүүлийн хагас, 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төсөв зэрэг болно.

Компанийн ТУЗ нь компанийн засаглалын дагуу мөрдөж буй дүрэм журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

### **⇒ Мэдээ мэдээлэл**

Мэдээ мэдээлэл нь тухайн тайлант хугацааны үйл ажиллагааг ил тод, нээлттэй байх зарчмыг баримталсан. Үүнд:

- Компанийн хууль, дүрэм болон бусад засаглалтай холбогдсон үйл ажиллагааны журмууд.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлын тов, хуралд хэлэлцэх асуудал, бүртгэлийн өдөр, хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудас, танилцах материалын жагсаалт зэргийг хууль дүрмийн дагуу өдөр тутмын сонин хэвлэлд 2 удаа, телевиз болон бусад мэдээлэх хэрэгслээр, хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчдийг өргөнөөр оролцуулахаар мэдээлж байлаа.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлын бэлтгэл ажлын графикийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг уг хуралд мэдээлсэн.
- Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах зорилгоор компанийн хувьцааны 5 хувиас дээш багцыг эзэмшигчид, компанийн жилийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан, санхүүгийн аудитлагдсан тайлан, ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалын тайлан зэргийг танилцуулж байлаа.
- Компанийн 2018 оны 4-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, 2018 оны 12-р сарын 26-ны өдрийн ээлжит бус хурлын үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх мэдээллийг зохих журмаар мэдээлж байв.

- Мөн тайлант жилд ажилласан эрх бүхий албан тушаалтнуудын талаарх зураг бүхий мэдээлэл.
- Компанийн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл компанийн ТУЗ-д сонгогдон ажиллаж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төслийг урьдчилан хүргүүлж тэдний санал зөвлөмжийг нь шийдвэрт тусган түүнийг хэрэгжүүлж байдаг юм.

⇒ **Хөрөнгийн зах зээл – Компанийн хувьцаа**

Хувьцааны 52 долоо хоногийн арилжаа ба ханш

д/д	Үзүүлэлт	2017 он	2018 он
1.	Гаргасан хувьцааны тоо	10,170,242.00	10,170,242.00
2.	Төрөл	энгийн	энгийн
3.	Арилжаалагдсан ширхэг	274,522.00	50,838.00
4.	Хаалтын ханш	2,229.00	1,801.00
5.	Хамгийн өндөр ханш	2,550.00	3100.00
6.	Хамгийн доод ханш	2,000.00	1,800.00
7.	Дундаж ханш	2,270.51	2,307.55
8.	Арилжааны үнийн дүн	535,461,087.00	117,311,072.00

Компанийн хувьцааны 5 хувиас дээш багцыг эзэмшигчид

Нийт хувьцаа 10,170,242

Д/Д	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Эзлэх хувь
1.	SHG HOLDINGS 3	2,318,451	22.79
2.	SHG HOLDINGS 2	2,028,906	19.94
3.	NIHAN HOLDINGS	1,598,889	15.72
4.	ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК	1,158,520	11.39
5.	SHG HOLDINGS 1	1,142,674	11.23
6.	MOGUL RESOURCES	1,000,000	9.83
	ДҮН	9,247,440	90.90

Компанийн нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийг дээрх хүснэгтээр үзүүлэв.

“Шарын гол” ХК нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 10,170,242 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд 1,016 хувьцаа эзэмшигчид уг хувьцааг эзэмшиж байна.

Компанийн хувьцаа нь “Ард капитал групп ҮЦК” ХХК, “Би Ди Сек ҮЦК” ХК, “Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК зэрэг брокер диллерийн компаниудад төвлөрсөн байна.

⇒ **Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал**

Тус компани нь компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурлыг КТХ-ийн дагуу жил бүрийн 4 дүгээр сард зарлан хуралдуулдаг. 2018 онд “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай” Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 06 дугаар тогтоол гарсан. Хурлыг 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр “Корпорейт хотел энд конвешн центр” зочид буудлын хурлын танхимд хуралдуулсан.

Энэхүү хуралд:

- ✓ Компанийн 2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх батлах. Компанийн ТУЗ-ийн ажил, засаглалын талаарх мэдээлэл.
- ✓ Компанийн дүрэмд өөрчлөлт оруулж шинэчлэн батлах. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны цалин урамшуулал, зардлын төсөв.
- ✓ Компанийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.
- ✓ Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл зэргийг хэлэлцэж шийдвэр гаргасан байна.

Энэхүү хурал 91.52 хувийн ирцтэй байв. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг товхимол болгон хэвлэж хуулийн хугацаанд брокер, диллерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа, хурлын шийдвэрийн талаарх мэдээллийг компанийн болон МХБ-ийн цахим хуудаст байршуулж, уг хурлын материалыг хууль, журмын хугацаанд СЗХ, МХБ-д хүргүүллээ.



**Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар  
сонгогдсон ТУЗ-ийн гишүүд**



**Г.Хулан**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



**Б.Багбаатар**

ТУЗ-ийн гишүүн /ердийн/



**Жеймс Пассин**

ТУЗ-ийн гишүүн /ердийн/



**Д.Байлхүү**

ТУЗ-ийн гишүүн /хараат бус/



**Б.Батмөнх**

ТУЗ-ийн гишүүн /ердийн/



**Б.Итгэл**

ТУЗ-ийн гишүүн /ердийн/



**М.Батсүрэн**

ТУЗ-ийн гишүүн /хараат бус/



**Казин Ник**  
ТУЗ-ийн гишүүн /ердийн/



**Ж.Эрдэмбилэг**  
ТУЗ-ийн гишүүн /ердийн/

### **Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал**

Компанийн “хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай” ТУЗ-ийн 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 33 дугаар тогтоол гарсан. Хурлыг 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 13 цагаас “Улаанбаатар зочид буудал”-ын хурлын танхимд хуралдууллаа.

Энэхүү ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах үндэслэл нь: Компанийн ТУЗ-ийн гишүүн Казин Ник чөлөөлөгдөх хүсэлт гаргасантай холбогдуулан, тус компанийн нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулж, ТУЗ-ийн шинэ гишүүн сонгуулах санал бүхий шаардлага ирүүлсэн тул Компанийн тухай хуулийн 62.1.7, дүрмийн 7.7.2 дахь заалтыг тус тус үндэслэн нэг гишүүнийг нөхөн сонгох боломжгүй, ТУЗ-ийн гишүүдийг бүрэлдэхүүнээр нь шинээр сонгож батлах болсон тул ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн юм.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудлыг 94.54 хувийн ирцтэйгээр хэлэлцэн зохих шийдвэр гаргасан. Ээлжит бус хурлын материалыг товхимол болгон, хуульд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн. Мөн хурлаас гарсан шийдвэрийг компанийн болон МХБ-ийн цахим хуудсаар мэдээлж, хурлын материалыг хууль, журмын хугацаанд СЗХ, МБХ-д хүргүүлсэн байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр доорхи нэр бүхий гишүүдийг сонгосон.

Үүнд: Ердийн гишүүдээр:

1. Б.Батбаатар
2. Б.Батмөнх
3. Жеймс Пассин
4. Б.Итгэл
5. Ө.Хишигсүх
6. Ж.Эрдэмбилэг

Хараат бус гишүүдээр:

1. М.Батсүрэн
2. О.Цэндсүрэн
3. Г.Хулан

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал хуралдаж Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Г.Хуланг сонгосон.

Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд Аудитын хорооны даргаар М.Батсүрэн, гишүүдэд О.Цэндсүрэн, Б.Итгэл, Нэр дэвшүүлэх хорооны даргаар

Ж.Эрдэмбилэг, гишүүдэд М.Батсүрэн, О.Цэндсүрэн, Цалин урамшууллын хорооны даргаар Г.Хулан, гишүүдэд М.Батсүрэн, Ө.Хишигсүх нарыг тус тус сонгосон.

**2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас  
сонгосон Төлөөлөн удирдах зөвлөл**



**Г.Хулан**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



**Б.Батбаатар**

ТУЗ-ийн гишүүн /ердийн/



**Жеймс Пассин**

ТУЗ-ийн гишүүн /ердийн/



**Ө.Хишигсүх**

ТУЗ-ийн гишүүн/ердийн/



**Б.Батмөнх**

ТУЗ-ийн гишүүн /ердийн/



**Б.Итгэл**

ТУЗ-ийн гишүүн /ердийн/



**М.Батсүрэн**

ТУЗ-ийн гишүүн /хараат бус/





**О.Цэндсүрэн**  
ТУЗ-ийн гишүүн /ердийн/



**Ж.Эрдэмбилэг**  
ТУЗ-ийн гишүүн /ердийн/

### ⇒ Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант хугацаанд ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүнтэйгээр ажилласан.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2018 онд төлөвлөсөн болон цаг хугацааны асуудлаар хэлэлцэх асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж байлаа. Хуралд гишүүдийг бүрэн оролцуулахын тулд, зарим гишүүдийн орон зайгаас шалтгаалан зарим хурлыг онлайн хэлбэрээр хуралдаж байв.

2018 ТУЗ-ийн хурлын 35 тогтоол гарсан. Үүнд:

- ТУЗ-ийн 2018 оны хурал, ТУЗ-ийн хороодын ажлын төлөвлөгөөний тухай
  - ТУЗ-ийн дарга сонгох тухай
  - ТУЗ-ийн хороодыг байгуулах тухай
  - Аудитын компани сонгох тухай
  - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурал хуралдуулах тухай
  - Компанийн удирдлага нэгжийн шинэчилсэн бүтцийг батлах тухай зэрэг компанийн удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр нийт 12 тогтоол.
- 2018 оны бизнес төлөвлөгөө батлах тухай
  - 2018 оны алт олборлолтын төлөвлөгөөний талаар
  - 2017 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлт гаргах зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны чиглэлээр 3 тогтоол.
- 2017 оны ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилах эсэх тухай
  - 2016, 2017 оны санхүүгийн аудитлагдсан тайлан батлах тухай
  - Зээлийн гэрээний хугацаа сунгах тухай
  - Барьцаат зээлийн тухай
  - Санхүүгийн түрээсийн гэрээ байгуулах зэрэг санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 14 тогтоол.
- Зарим эд хөрөнгө акталж данснаас хасах тухай.
  - Урамшуулал олгох тухай
  - Нүүрсний үнийн тухай зэрэг бусад асуудлаар 6 тогтоол тус тус гаргасан байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа компанийн засаглалын кодекс, зарчмыг мөрдлөг болгон компанийн засаглалын хөгжлийг манлайлагчдын эгнээнд багтаж ажиллахыг зорин ажиллаж байгаа билээ.

**2018 ОНД АЖИЛЛАСАН КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА**



**Б.Батбаатар**  
Гүйцэтгэх захирал



**Ө.Хишигсүх**  
Ерөнхий Захирал



**Ж.Эрдэнэбат**  
Үйлдвэрлэл  
эрхэлсэн дэд  
захирал



**М.Мөнхболор**  
Санхүү эрхэлсэн  
дэд захирал



**Л.Даваасүрэн**  
Ерөнхий нягтлан  
бодогч

## **КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ**

Тус компани нь 2018 оны ажлын амжилтаар Дархан-Уул аймгийн хэмжээнд шалгарч, Дархан-Уул аймгийн “ОНЫ ТЭРГҮҮНИЙ БАЙГУУЛЛАГА”-аар өргөмжлөгдсөн. Мөн 2017 оны ажлын амжилтаар Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас шалгаруулж байгаа “ҮНДЭСНИЙ ТОП-150 АЖ АХУЙН НЭГЖ”-д шалгарлаа.

Энэхүү үнэлгээ нь манай компани 2018 онд үүргээ амжилттай биелүүлсний илэрхийлэл байлаа.





**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Г Компанийн 2018 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайлангийн талаар  
дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.11, компанийн дүрмийн 8, 15, 11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт, тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцүүлэн батлуулахыг ТУЗ-ийн дарга /Г.Хулан/-д даалгасугай.

ДАРГА Г.ХУЛАН



Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 4 сарын 26

дугаар 01

Улаанбаатар

Компанийн жилийн үйл ажиллагааны болон  
Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн  
удирдах зөвлөлийн дүгнэлтийн тухай

“Шарын гол” хувьцаат компанийн 2018 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд,

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Шарын гол” хувьцаат компанийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХУЛАН

Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 4 сарын 26

дугаар 02

Улаанбаатар

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2019 оны цалин урамшуулал, зардлын төсөв  
батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны цалин урамшуулал, зардлын төсвийг /хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХУЛАН



"Шарын гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
хурлын 2019 оны 4-р сарын 26-ны  
өдрийн \_\_\_\_ дугаар тогтоолын хавсралт

**"Шарынгол"ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны зардлын төсөв**

*(мян.төг)*

д/д	Зардлын төрөл	НИЙТ ЗАРДАЛ м.төг
1	ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин	171,000.0
2	НДШ	23,940.0
	<b>Дүн</b>	<b>194,940.0</b>

Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2019 оны 4 сарын 26

дугаар 03

Улаанбаатар хот

Хувьцаа нэмж гарган,  
“Хай Би Ойл” ХК-д төлөх өрийг  
хувьцаагаар солих тухай

Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 61.1.3, ТУЗ-ийн хурлын шийдвэр, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Өрийг хувьцаагаар солих зорилгоор 1,139,627 ширхэг энгийн хувьцаа нэмж гаргасугай.
2. Өрийг хувьцаагаар солих зорилгоор нэмж гаргасан хувьцааны нэгжийн үнийг “Хай Би Ойл”ХХК-гай тооцоо нийлсэн 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөр тасалбар болгосон хувьцааны сүүлийн 6 сарын дундаж жигнэсэн ханшийг үндэслэн гаргасан 1,929.32 төгрөгөөр тогтоосугай.
3. “Хай Би Ойл ХК”-д төлөх 2,198,705,477.52 төгрөгийн өрийг нэмж гаргаж буй 1,139,627 ширхэг энгийн хувьцаагаар сольсугай.
4. Өрийг хувьцаагаар сольж буйтай холбогдуулан өрийг хувьцаагаар солих төслийг тогтоолын хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХУЛАН

Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2019 оны 4 сарын 26

дугаар 04

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн дүрмийн 4.2 дахь заалтын “Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10.170.242 (Арван сая нэг зуун далан мянга хоёр зуун дөчин хоёр ) ширхэг энгийн хувьцаа (цаашид “Хувьцаа” гэх) гаргах эрхтэй. Энэ хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн ХЭ-ийн хурлаар шийдвэрлэнэ” гэснийг “Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 11.309.869 (Арван нэгэн сая гурван зуун есөн мянга найман зуун жаран ес) ширхэг энгийн хувьцаа (цаашид “Хувьцаа” гэх) гаргах эрхтэй. Энэ хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн ХЭ-ийн хурлаар шийдвэрлэнэ” гэж өөрчилсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХУЛАН



Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2019 оны 4 сарын 26

дугаар 05

Улаанбаатар хот

Нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид  
худалдан авах давуу эрхээ хувьцаа  
эзэмшигч хэрэгжүүлэх эсэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 61.1.8 дахь хэсэг, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хувьцаа эзэмшигчдэд.....байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХУЛАН

## “ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

### Ердийн гишүүнд нэр дэвшигчид

#### Бадангийн Батбаатар



- 1977 Варшав хотод төрсөн
- 2000 онд Жорж Мейсоны их сургууль төгссөн /бакалавр/
- 2004 онд Жорж Вашингтоны их сургууль төгссөн /магистр/
- Бизнесийн удирдлага, санхүүч мэргэжилтэй
- 2006-2007 онд Мянганы сорилын санд
- 2007-2009 онд “Си Си Пи” ХХК-д
- 2009 оноос одоо хүртэл “Си Би Эм” ХХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан
- 2014 оны 6-р сараас “Шарын гол” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

#### Батбаярын Тулга



- 1986 онд Дархан-Уул аймагт төрсөн
- 2008 онд Санхүү Эдийн засгийн сургууль
- Бизнесийн эдийн засагч мэргэжилтэй
- 2008-2009 онд Зоос банканд зах зээлийн эдийн засагч, аудитор
- 2009-2011 онд Төрийн банканд хянан шалгагч, зах зээл үйл ажиллагааны эрсдэл
- 2011-2012 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд эрсдэлийн эдийн засагч
- 2012-2013 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд зээлийн эдийн засагч
- 2013-2016 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байгууллагын санхүүжилтийн хэлтсийн дарга
- 2016-2017 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байгууллагын банкны газрын дарга
- 2017 оноос Үндэсний хөрөнгө оруулалтын банкны гүйцэтгэх захирлаар.

#### Борхүүгийн Гантулга



- 1987 онд Дорнод аймгийн Чойбалсан суманд төрсөн
- 2009 онд ШУТИС төгссөн
- Геологич мэргэжилтэй
- 2010-2011 онд “Хулаан Коал” ХХК-д геологич
- 2011-2013 онд “Си Би Эм” ХХК-д Төслийн геологич
- 2014-2016 онд “Товь Караван” ХХК-д Төслийн геологич
- 2017-2018 онд “Нагай” ХХК-д Уурхайн дарга
- 2019 оноос “Нагай” ХХК-д Уурхай хариуцсан захирал

### **Болдын Итгэл**



- 1986 онд Улаанбаатар хотод төрсөн
- 2005 онд АНУ-ын Иорктауны ахлах сургууль
- 2008 онд АНУ-ын Жорж Мейсоны их сургууль тус тус төгссөн
- Санхүүч мэргэжилтэй
- 2009-2010 онд Хаан банканд теллер, зээлийн эдийн засагч, харилцааны менежер
- 2010-2013 онд “Ньюком” ХХК-д шинжээч, хөрөнгө оруулалтын менежер
- 2013 оноос одоо хүртэл “Нова Терра” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
- 2018 оноос “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн.

### **Өрнөхийн Хишигсүх**



- 1958 онд Улаанбаатар хотод төрсөн
- 1979 онд ЦНДС төгссөн
- 1984 онд ЦАТТ академи төгссөн
- 1979-1981 онд Ардын армийн 133-р ангид авто техникийн албаны дарга
- 1981-1984 онд МУИС-д багш
- 1987-1989 онд Ардын армийн 133-р ангид штабын дарга
- 1989-1990 онд СОТ-1 АТК-3-д дарга
- 2000-2016 онд “Өргөө” ХХК-д захирал
- 2016 оноос БХИС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүн
- 2018 оны 6-р сараас “Шарын гол” ХК-ийн Ерөнхий захирлаар ажиллаж байна

### **Жүгдэрнамжилын Эрдэмбилэг**



- 1976 онд Улаанбаатар хотод төрсөн
- 1994 онд МУИС-ийн Эдийн засгийн сургууль
- 2003 онд Удирдлагын академи-д суралцаж төгссөн
- Эдийн засагч мэргэжилтэй
- Бизнесийн удирдлагын магистр
- 1998-2004 онд Төрийн өмчийн хороонд мэргэжилтэн
- 2005-2009 онд “Энержи-Ресус” ХХК-д төслийн менежер
- 2010-2011 онд Эрдэс баялаг эрчим хүчний яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтэст
- 2016 оноос одоо хүртэл “Говь караван” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа
- 2018 оноос “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

### Тэрбишийн Говьдэлгэр



- 1984 онд Говь-Алтай аймагт төрсөн.
- 2001 онд Говь-Алтай аймгийн 10 жилийн сургууль
- 2001-2005 онд МУИС-ийн ГГФ-ийг геологич мэргэжлээр төгссөн.
- 2005-2007 онд “Адемас майнинг” ХХК-д геологич
- 2007-2011 онд “Вюмир майплесон” ХХК-д геологич
- 2011-2015 онд “Си Би Эм” ХХК-д геологич
- 2015-2017 онд “Говь караван” ХХК-д геологич
- 2017 оноос “Нагай” ХХК-д геологичоор ажиллаж байна.

### Хараат бус гишүүдэд нэр дэвшигчид

#### Мажигсүрэнгийн Батсүрэн



- 1977 онд Улаанбаатар хотод төрсөн
- 2001 онд Улаанбаатар дээд сургууль төгссөн
- Хэрэглээний математикч мэргэжилтэй
- “Хай Би Ойл” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
- 2018 оноос “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

#### Охиндойн Цэндсүрэн



- 1965 онд төрсөн.
- 1983-1989 онд ОХУ, Уул уурхайн дээд сургууль-уул уурхайн инженер
- 1995-1997 онд Техникийн Их Сургууль- магистр
- 1996-1999 онд Улаанбаатар эрдэм дээд сургууль-хууль зүйн бакалавр
- 2002-2004 МУИС, Хууль зүйн сургууль-Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан.
- 2003-2008 онд ОХУ, Екатеринбург хот Уул уурхайн академи-докторын сургалтанд хамрагдсан.
- 2007 онд ШУТИС, зөвлөх инженерийн сургалт тус тус төгссөн.
- Уул уурхайн инженер, Эрх зүйч мэргэжилтэй
- 1998-2000 онд ХХААҮЯам-ГУУСалбарын олборлолтын бодлого, хууль, эрх зүйн бодлого хариуцсан мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн.
- 2000-2002 онд Үйлдвэр худалдааны яам-ГУУСалбарын хамтарсан үйлдвэр, хууль, эрх зүйн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүн.
- 2002-2004 онд Үйлдвэр худалдааны яам-ГУУ-н бодлого зохицуулалтын газрын дэд дарга, эрдэс баялгийн мэргэжлийн



зөвлөлийн дэд дарга.

- 2003 онд Үйлдвэр худалдааны яам-ГУУ-н бодлого зохицуулалтын даргын үүрэг гүйцэтгэгч, ГУУ-н салбарын мэргэжилтэнд мэргэшил, зөвлөх инженерийн зэрэг цол олгох комиссын дарга.
- 2004-2007 онд Үйлдвэр худалдааны яам-Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын дэд дарга.
- 2008 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл-Геологи, уул уурхайн асуудал хариуцсан шинжээч.
- 2010-2015 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба-Эрдэс баялаг,эрчим хүчний асуудал хариуцсан ахлах референт
- 2015 онд Уул уурхайн яам-Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дарга

### **Гэрэлийн Хулан**



- 1985 онд Токио хотод төрсөн
- 2000 онд Японы “Шото” дунд сургууль
- 2004 онд Японы “Кокусан” ахлах сургууль
- 2008 онд Японы Азийн их сургууль тус тус төгссөн
- Гадаад харилцааны мэргэжилтэй
- 2011-2013 онд “Солонго Эко Кампинг” ХХК-ийн ерөнхий захирал
- 2014-2018 онд “Интернационал Смарт Акуа Калча” /ИСАК/ ерөнхий менежер
- 2017-2018 онд “Данфийн ГХО” ХХК гүйцэтгэх захирлаар одоо хүртэл ажиллаж байна
- 2018 оноос “Шарын гол ХК-ийн” ТУЗ-ын дарга.

Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2019.04.26

дугаар 06

Шарын гол

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн  
ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, компанийн дүрмийн 8.3 дахь заалт,  
хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд

-  
-  
-  
-  
-  
-

Хараат бус гишүүнд

-  
-  
-

нарыг

2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал  
хүртэл 2 жилийн хугацаагаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХУЛАН



**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Г Ногдол ашгийн тухай Г

“Шарын гол” ХК-ийн 2018 оны нүүрс борлуулалтын төлөвлөгөөний биелэлт 118.4 хувь, санхүүгийн тайлангаарх татварын дараах үр дүн 1.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, компанийн санхүүгийн байдал зохих түвшинд хүрээгүйг тэмдэглээд, Компанийн тухай хуулийн 46.1, компанийн дүрмийн 12 дугаар бүлгийн заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2018 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоол, түүнтэй холбогдсон шалтгаан, тооцоолол бүхий тайлбарыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА Г.ХУЛАН



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны  
..... дугаар тогтоолын хавсралт №1

“Шарын гол” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлын хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчээс

### САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр .....  
Регистрийн дугаар .....  
ХЭ-ийн бүртгэлийн дугаар .....  
Эзэмшиж буй хувьцааны төрөл .....  
Тоо .....

Хурал 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 13 цагаас “Улаанбаатар” зочид буудлын  
хурлын танхимд болно.

д/д	Хэлэлцэх асуудлын нэр	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт. ТУЗ-ийн ажлын тайлан	Тогтоол ТУЗ-ийн дүгнэлтийг батлах				
2	Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2019 оны цалин урамшуулал, зардлын төсвийг батлах	Тогтоол Зардлын төсвийг батлах				
3	Компанийн өрийг хувьцаагаар солих, түүнтэй холбоотойгоор хувьцаа нэмж гаргах	Тогтоол Компанийн өрийг хувьцаагаар солих болон нэмж хувьцаа гаргах тухай				
4	Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.	Тогтоол Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах				
			Давуу эрхээ эдэлнэ	Давуу эрхээ эдлэхгүй		
5	Нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэх эсэх	Тогтоол Тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай				
6	Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох		Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/			
	1					
	2					



	3		
	4		
	5		
	6		
	<i>Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох</i>		<i>Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/</i>
	1		
	2		
	3		
	4		
8	<i>Ногдол ашиг хуваарилаагүй тухай танилцуулга</i>		<i>Мэдээлэл тул санал хураахгүй</i>

***Саналын хуудас хүлээн авах эцсийн өдөр 4 дүгээр сарын 26 болно.***

*Санал өгсөн хувьцаа эзэмшигчийн гарын үсэг .....*

*Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон*

*Тооллогын комиссын дарга .....*

*гишүүд: .....*

*.....*

*Хүчингүйд тооцсон бол шалтгаан*

*.....*

*.....*

***Санал авах хуудсын ашиглах санамж***

1. Санал өгөх тэмдэглэл  $\checkmark$  тэмдэглэнэ.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгоход санал хураах Кумулятив аргыг хэрэглэнэ. Кумулятив аргаар санал өгөх тоо \_\_\_\_\_
  - Тайлбар: саналын эрх бүхий энгийн хувьцааны тоог 9-өөр үржүүлж нийт саналын эрхийн тоог гаргана. Энэ нь энгийн хувьцааны болон хараат бус гишүүнд өгсөн саналын нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгөх бөгөөд энгийн гишүүнд нэр дэвшиж буй 1-6 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 2/3-ыг, хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 1-3 хүртэл тооны хүнд нийт саналын 1/3-ийг өгсөн байна. Энэ хуваарийг зөрчиж санал өгсөн бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.
3. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс болон “Шарын гол” ХК-ийн УБ дахь Төлөөлөгчийн газар дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгч болно.
4. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 88026677, 99155399 утсаар лавлаж болно.